БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

2024 оны 01 дүгээр сарын 09 Номгон

| Үнэлгээ | | | Гэрээний заалт | Хавсралт |
|---|---|---|---|---|
| 1 | | | 2 | 3 |
| Арга хэмжээний тоо | | | 106 | |
| Үнэлгээ | Үр дүнтэй 100% | 100% | 90 | |
| | Тодорхой үр дүнд хүрсэн 70%-99% | 90% | 11 | |
| | | 70% | 3 | |
| | Эрчимжүүлэх шаардлагатай 31%-69% | 50% | 2 | |
| | | 30% | - | |
| | Үр дүнгүй | 0% | - | |
| | Хэрэгжсэн хувь | | 97.1% | |
| **ДУНДАЖ ХУВЬ** | | | **97.1%** | |

ТАНИЛЦСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Д.МӨНХСАЙХАН

ХЯНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ

ТОВЧООГ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Б.НАРАНЦЭЦЭГ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Номгон

2024 оны 01 дүгээр сарын 09

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт-1. Байгууллагын албан хаагчдын ёс зүй, чадахуйн зарчмыг төлөвшүүлж, үйл ажиллагааны чанар хүртээмж, ил тод байдлыг сайжруулах** | | | | | | | |
| 1.1 | Аймгийн ЗДТГ-ын 2023 онд ажиллах бүтэц орон тоо, цалингийн санг шинэчлэн тогтоох | 1 тэрбум 628.655.8 00 төгрөг | Төрийн захиргааны 42, Төрийн тусгай-4, Улс төрийн-2, төрийн үйлчилгээний 36, гэрээт 16, албан хаагчийг цалинжуулах, цалингийн сангийн шинэчлэлт 100% хийсэн байна. | 1 тэрбум 224.84 7.489 төгрөг | 100% | Байгууллагын даргын 2023 оны А/01 тоот тушаалаар бүтэц, орон тоо, цалингийн санг шинэчлэн тогтоож хүний нөөцийн системд 98 албан хаагчдын мэдээллийг шинэчлэн бүртгэв. | 100% |
| 1.2 | Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулах | - | Нийт 52 албан хаагчийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан байна. | 53 | 60 | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор 60 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж, төрийн үйлчилгээний нийт 12 албан хаагчтай шинээр хөдөлмөрийн гэрээг байгуулав. | 100% |
| 1.3 | Байгууллагын албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгаанд үндэслэн сургалт, нийгмийн баталгаа хангах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах | - | Хөтөлбөрийг хугацаанд нь батлуулсан байна. хэрэгжилтийн хувь | 0% | 100% | Сургалтын төлөвлөгөөг 17 ажил, арга хэмжээний дагуу, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг 20 ажил, арга хэмжээ төлөвлөж, сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 82.3 хувь нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 78 хувьтай байна. Албан хаагчдыг эрт илрүүлэгийн үзлэгт хамруулж, хүүхдийн өрөөг тохижуулсан. | 100% |
| 1.4 | Төрийн болон аймгийн шагналд тодорхойлолт ирүүлсэн иргэдийн материалд хяналт тавих, саналыг | - | Уламжилсан иргэдийн тоо, шийдвэрлэлтийн хувиар | 415 | 300 | Төрийн болон аймгийн шагналд тодорхойлсон иргэдийн материалд хяналт тавьж, Төрийн шагналд нийт 707 иргэний материалыг шагналын програмд | 100% |

| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх | | | | | | бүртгэн, Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан байна. Үүнээс Ерөнхийлөгчийн зарлигаар 125 иргэн шагнагдсан байна. | |
| 1.5 | Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөгөөн зохион байгуулах | | - | Зөвлөгөөнд оролцсон, албан хаагчдын тоо | 200 | 200 | "Ёс зүйгээр манлайлъя" сургалт, зөвлөгөөн, спортын бага наадмыг аймгийн Засаг даргын тамгын газар, 20 сумын Засаг даргын Тамгын газрын 500 орчим төрийн албан хаагчдыг хамруулан 2 өдрийн турш зохион байгуулж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 25.5 сая төгрөгийг зарцуулла. | 100% |
| **Зорилт-2. Цахим технологид тулгуурлан төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцлийг бүрдүүлэх, ил тод байдлыг сайжруулах** | | | | | | | | |
| 2.1 | Байгууллагын бичиг төлөвлөлт, хяналтын системийн eoffice.bayanhongor.gov.mn, irgen.bayanhongor.gov.mn цахим системийн ашиглалтыг сайжруулах, хяналт тавих | | - | Агентлаг, сум байгууллагын цахим системийн ашиглалтын хувиар | 45% | 55% | 2023 оны 12 сарын 04-ний өдрийн байдлаар байгууллагын бичиг төлөвлөлт, хяналтын eoffice.bayanhongor.gov.mn цахим системээр нийт 79 байгууллага 2945 албан бичиг төлөвлөн боловсруулснаас 50 албан бичгийг тухайн байгууллагын дарга татгалзаж 2895 шийдвэр, албан тоот баталгаажсан байна. | 100% |
| 2.2 | Баянхонгор аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.1 дэх заалт | Иргэдэд зориулсан "Хамтдаа шийдье" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх | Орон нутгийн хөгжлийн сан-53.0 | Хамрагдсан өрхийн тоо | 0 | 5000 | Монгол Улсын Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Нээлттэй Баянхонгор, Баялаг бүтээгч Баянхонгор, Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган, Соёлын сэргэлт нэгдсэн арга хэмжээнүүдийг 2023 оны 09 дүгээр сарын 22-23-ын өдрүүдэд Баянхонгор аймагт 20 сумын 1000 малчин, 150 газар тариалан эрхлэгч, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийг хамруулан амжилттай зохион байгуулсан. Зөвлөгөөний үеэр малчдын дунд урлаг, спортын 18 төрлийн уралдаан, тэмцээн, -Эрүүл мэндийн үзлэгийн үеэр эрт илрүүлэгт 90, урьдчилан сэргийлэх үзлэгт 191 нийт 28 малчин иргэнийг сайн дурын үзлэг, шинжилгээнд хамруулсан. Төрийн 19 байгууллага хамтран "Нээлттэй | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдөрлөг”-ийг зохион байгуулж үйл ажиллагаагаа 3000 гаруй иргэнд танилцуулж 1120 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлснээс 200 гаруй иргэнд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгч, хууль эрх зүйн мэдээлэлтэй хөзөр, 20 төрлийн 3750 ширхэг гарын авлагыг тараасан. | |
| 2.3 | Баянхонгор аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.2 дахь заалт | Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйлчилгээний чанарыг сайжруулж, цахим мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт хийх | Орон нутгийн хөгжлийн сан-270.0 | Үйлчлүүлсэн иргэдийн тоо, цахим системийн хөгжүүлэлтийн хувь | 459 | 909 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 270 сая төгрөгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн ХУРДАН төвийг 2023 оны 04 дүгээр сард шинээр байгуулж төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүллээ. Тус төвийг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжид 19,5 сая, өрөөний тохижилтод 16,5 сая төгрөг зарцуулав. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас шинээр хөгжүүлэлт хийсэн huduu.mn цахим платформд Баянхонгор аймгийн суурь мэдээллийг бүрэн оруулсан. https://www.huduu.mn/baynkhongor цахим хуудсанд Баянхонгор аймагт шилжин ирэх иргэдэд зориулсан боломж, ажлын байр, газар олголт, бизнесийн орчин, татварын хөнгөлөлт зэрэг мэдээллийг байршуулж байнга шинэчлэн ажиллаж байна. | 100% |
| 2.4 | Байгууллагын баримт бичиг төлөвлөлтийн цахим системээр захиргааны актыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавихад мөрдөх журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих | | - | Хэрэгжилтийн хувиар | 40% | 95% | Аймгийн Засаг даргын А/168 дугаар захирамжаар Бичиг төлөвлөлтийн цахим системээр захиргааны актыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавихад мөрдөх нийтлэг журмыг баталж хэрэгжилтийг хангаж, сумдын ЗДТГ болон төрийн байгууллагуудад 3 удаагийн сургалт зохион байгуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5 | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг ханган, үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг сурталчлах ажлыг зохион байгуулах | - | Аймаг орон нутгийн албан ёсны Bayanhongor.gov.mn цахим сайтын ашиглалт, байршуулсан мэдээллийн тоо, хандалтын хувь | 30% | 60% | “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлд заасан 98 төрлийн шалгуур үзүүлэлтийг bayanhongor.gov.mn цахим хуудсанд бүрэн байршуулсан. Аймгийн цахим хуудасны үнэлгээ 2023 онд 100%-тай буюу өмнөх онтой харьцуулахад 33%-иар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн албан ёсны bayanhongor.gov.mn цахим хуудсанд 2023 онд зохион байгуулсан ажил, арга хэмжээний 342 мэдээ мэдээллийг бэлтгэн байршуулсны зэрэгцээ олон нийтийн сүлжээ ашиглан иргэд, олон нийтэд хүргэж ажилласан байна. Сайтын Хандалтын тоо энэ 2023 оны жилийн эцсийн байдлаар 5186 буюу өмнөх онтой харьцуулахад 50%-иар өссөн үзүүлэлтэй байна. | 100% |
| **Зорилт-3. Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах агентлаг, сум, багийн үйл ажиллагааг уялдуулах, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 3.1 | Баянхонгор аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.3 дахь заалт<br>Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах | | Тайлангийн ирц, чанарын хувиар | Ирц:90 %<br>Чанар: 70,56 % | Ирц:95 %<br>Чанар:72% дээш | Жилийн хөгжлийн төлөвлөгөөний хавсралтаар батлагдсан 39 арга хэмжээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тайлагнаж, 6.1.3 заалтын задаргааны 21 арга хэмжээний хэрэгжилт 67 хувийн хэрэгжилттэй нийт төсөв 273,0 сая төгрөгийн санхүүжилтээс 134.746.960 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 138.253.040 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг эрчимжүүлж, хөрөнгө санхүүжилтийг үр дүнтэй зарцуулж ажиллах талаар бодлогын хэлтсүүдэд чиглэл хүргүүлж ажилласан. | 90% |
| 3.2 | Агентлаг, сум, байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн шийдвэрийн тайлагналт хариуцсан ажилтан, | | Хэрэгжилтийн хувиар | 50% | 90% | Сум агентлагийн тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнүүдэд “Чадваржуулах сургалт”-ыг 2023 оны 03 дугаар сард 104 албан хаагчдад зохион байгуулсан. Мөн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан хаагчдыг мэргэшүүлэх, чадваржуулах, арга зүйгээр хангах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах | | | | | сумдад "Төрийн бүтээмж ба үнэлгээ мониторинг" сургалтыг 4 суманд бүсчилсэн байдлаар зохион байгуулж, сумдын тайлан хянан баталгаажуулдаг удирдлагууд, холбогдох албан хаагчдыг хамруулж тайлангийн ирц, чанар, цаашид анхаарах асуудлын талаар сургалт хийсэн. Мөн тайлан мэдээ хариуцсан албан хаагчдын групп чат үүсгэж тайлангийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэлийг товч тодорхой, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байдлаар иж бүрэн, алдаа мадаггүй нотлогдохуйц тайлагнах талаар тухай бүр заавар зөвлөмж өгч ажиллаж байна. | |
| 3.3 | Агентлаг, сум, байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, тайлагналтад хяналт шинжилгээ үнэлгээ хийх, зөвлөмж хүргүүлэх, үр дүнг тооцох, урамшуулах | | Хэрэгжилтийн хувиар | | | Аймгийн Засаг даргын харьяа 24 агентлаг, 20 сум, 10 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн 2022 оны жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүнг удирдлагын зөвлөлд танилцуулан аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн дээр эхний 5 сум, 5 агентлаг, 2 орон нутгийн өмчийн байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын 2 хэлтэст нийт 37,8 сая төгрөгийн мөнгөн шагналыг цом батламжийн хамт гардуулан урамшуулав.<br>Сумд, байгууллага, хэлтсүүдийн 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайланг, зөвлөмжийн хамт байгууллага, нэгж тус бүрт хүргүүлсэн. Сар бүрийн тайланд цахимаар зөвлөмж өгч | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласнаар тайлангийн хэрэгжилт 1.02-6.1 хувь ахисан байна. | |
| 3.4 | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сум, байгууллагын дарга нартай гүйцэтгэлийн төлөвлөгөө баталгаажуулах, хамтран ажиллах гэрээ байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулах | - | Гэрээний хэрэгжилт хангагдсан хувиар | ..... | 10% | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24, орон нутгийн өмчит 10 байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг, 20 сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээг цахимаар болон цаасаар батлан, гэрээ байгуулах үйл ажиллагааг ёслолын өндөр түвшинд зохион байгуулж ажилласан. | 100% |
| 3.5 | Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хянах, бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих. | - | Хяналтад авсан захиргааны актын тоо, хэрэгжилтийн хувиар | 45% | 90% | Тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа (байр)-ны төлбөрийн хэмжээг шинэчлэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 14/27 дугаар тогтоолоор батлуулан, ХЗДХЯ-нд хянуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6238 дугаарт, Цагийн хязгаар шинэчлэн тогтоох тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/602 дугаар захирамжийг батлан ХЗДХЯ-нд хянуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6472 дугаарт тус тус бүртгүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. | 100% |
| 3.6 | Засаг даргын дэргэдэх удирдлагын баг, байгууллага, удирдах ажилтнуудын шуурхай хурлыг зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг албажуулан, архивт өгөх | - | Хэрэгжилтийн хувиар | 50% | 95% | Аймгийн Засаг даргын дэргэдэх удирдлагын баг 3 удаа, байгууллагын удирдах ажилтны шуурхай мэдээллийн цагийг 9 удаа аймгийн "Удирдах ажилтны зөвлөгөөнийг 1 удаа тус тус зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн 262 удирдах албан тушаалтан оролцсон. | 100% |
| **Зорилт 4. Монгол Улсын гадаад бодлогод нийцүүлэн холбооны гишүүн орнуудтай харилцаа холбоогоо улам өргөжүүлэх, хамтран төсөл хэрэгжүүлж, худалдаа эдийн засгийн харилцааг шинэ түвшинд хүргэх** | | | | | | | |
| 4.1 | Гадаад улс орнуудтай байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийг хангах, харилцаа холбоог | - | Хэрэгжилтийн хувиар | 20% | 60% | Гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу БНХАУ-ын Гансу муж, Баянхонгор аймаг хооронд нөхөрсөг харилцаа байгуулах санамж бичиг, Гансу мужийн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэхжүүлэх ажил арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах | | | | | Жючюань хот, Баянхонгор хот хооронд нөхөрсөг харилцаа байгуулах санамж бичгийг тус тус байгуулан, санамж бичгийн хүрээнд боловсрол, соёл урлаг, хөдөө аж ахуйн салбарт бодит хамтын ажиллагааг эхлүүлэв.<br>Тус санамж бичгийн хүрээнд 1.БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Альша аймгийн Баруун хошууны Ингэний сүүний үйлдвэрлэлтэй танилцах 17 иргэнийг туршлага судалсан.<br>2.БНХАУ-ын Жюучань хотод хүлэмжийн аж ахуйн техникчээр-3, бордоо бэлтгэх техникчээр-2, ой мод үржүүлгийн технологичоор 1 нийт 6 хүнийг дадлагажуулж сургасан.<br>3.БНХАУ-ын Жюучань хотын Технологийн коллежид-20, Ланжоугын Их сургуульд 10 оюутан суралцаж байна.<br>4.Гансу Мужийн Сүбэй шань-с хөтлөгч-1, уртын дууч-2, кирилл бичиг сурах-2, музейн чиглэлээр-1 нийт 6 хүний бүрэлдэхүүн ирж туршлага судалсан. | |
| 4.2 | Ингэний сүүний үйлдвэрээс гарах эцсийн бүтээгдэхүүний экспортын зах зээлийг судлах, гадаад түнш байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлэх | - | Хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн хувиар | 35% | 75% | БНХАУ-ын ӨМӨЗО-ын Альшаа аймгийн Баруун хошуу болон Эзнээ хошуутай хамтын ажиллагааг эхлүүлж, тэнд үйл ажиллагаа эрхэлдэг ингэний сүүний үйлдвэр, фермерийн үйл ажиллагаатай төрийн байгууллагын болон малчдын 20 гаруй төлөөлөл танилцан, туршлага судласан. Туршлага судалж ингэний сүүний үйлдвэрт сүү нийлүүлэх, ферм байгуулахаар Бөмбөгөр сумын малчин С.Болдбаатар, Шинэжинст сумын малчин Ш.Дашбалдан, Жинст сумын малчин Н.Ганболд, Бууцагаан сумын малчин Д.Хандаа Баян-Өндөр сумын малчин Д.Дэлгэрдалай, Хүрээмарал сумын | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | малчин С.Насанжаргал нар хөрөнгө оруулалтын чуулганаар санамж бичиг байгуулан хамтран ажиллахаар болов. Ингэний сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг БНХАУ-ын Шанхай хотоос 2.5 тэрбум төгрөгөөр худалдаж авч, угсралтын ажил 80 хувьтай хийгдэж байна. Азийн сүүний холбоотой хамтран кластераар ингэний хуурай сүү үйлдвэрлэх, гадаад зах зээлийн боломжийг судлан хамтран ажиллаж байна. | |
| 4.3 | Аймаг, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын салбаруудын нэгдсэн судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих | | Хэрэгжилтийн хувиар | 10% | 50% | Аймагт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын салбарын байгууллагуудын нэгдсэн судалгаа бүхий мэдээллийн сантай бөгөөд энэ оны мэдээллийн шинэчлэлийг бүрэн хийсэн. Мөн аймгийн зочлох байгууллагын удирдлага, үйлчилгээний ажиллагсдад үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах сургалтыг зохион байгуулсан. | 100% |
| **Зорилт-5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хянах, бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих** | | | | | | | |
| 5.1 | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангаж ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллах, хяналт тавих | - | Төлөвлөгөөний биелэлтийн хувиар | Эхний хагас жилд: 49 хувь Сүүлийн хагас жилд: 50 хувь | Эхний хагас жилд: 50 хувьд хүргэх Сүүлийн хагас жилд: 50 хувьд хүргэх | Шинээр батлагдсан хууль тогтоомж, Согтууруулах ундаагийн эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хүрээнд ХХААХҮЯ-наас ирүүлсэн 2 журмын төсөлд санал хүргүүлэн ажилласан. | 100% |
| 5.2 | Зөвшөөрлийн тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангах | | Төлөвлөгөөний биелэлтийн хувиар | Эхний хагас жилд: | Эхний хагас жилд: | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 50 хувь | 50 хувьд хүргэх | холбогдох журмаар давхардсан тоогоор 810 худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт цахимаар болон танхимын сургалтыг зохион байгуулж, 430 аж ахуйн нэгжид 4 төрлийн 1720 гарын авлагыг түгээж ажиллалаа. | |
| 5.3 | Шинээр батлагдсан болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл лавламжийн сан бүрдүүлэх, өөрчлөлт, хөдөлгөөнийг хийх | - | Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн хуулийн тоогоор | Сүүлийн хагас жилд: 115 хууль | Сүүлийн хагас жилд: 115 хууль | ХЭЗХэлтсийн лавламжийн санг төрийн мэдээлэл эмхэтгэл 22 ширхэг болон Захиргааны хэм хэмжээний актын 12 ширхэг эмхэтгэлээр тус бүр баяжуулан ажиллаж байна.<br>Төрийн мэдээллийн эмхтгэл сэтгүүлийн 2 дугаарын 45 хуульд нэмэлт өөрчлөлт хөдөлгөөнийг хийж ажиллалаа. | 100% |
| 5.4 | Сум, байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэлийн нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах | - | Зөвлөгөөнд оролцогчдын тоогоор | Эхний хагас жилд: 100 хувь | - | Төрийн архивын болон сум, байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудын “Архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэлт-өөрчлөлт” зөвлөгөөнийг зохион байгуулан 180 байгууллагын 200 ажилтан оролцлоо. | 100% |
| 5.5 | Байгууллагын 2023 оны тусгай төрлийн баримтыг Төрийн архивт шилжүүлэх | Байгууллагын төсөв | Тусгай төрлийн баримтын тоо | 2 | 10 | “Байгууллагын 2023 оны тусгай төрлийн 22 баримтыг Төрийн архивд хүлээлгэн өгсөн. | 100% |
| 5.6 | Нэгжүүдийн 2022 оны баримтыг байгууллагын архивт хүлээн авах | - | -Баримтын тоо,<br>-Хуудасны тоо | -268,<br>-10590 | -368,<br>-12050 | Нэгжүүдийн 2022 оны байнга, түр, 70 жил хадгалах баримтыг байгууллагын архивд хүлээн авсан. | 90% |
| **Зорилт 6. Хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, худалдаа үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлэх** | | | | | | | |
| 6.1 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх | 100.0 /Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал/ | -Шинээр гаргасан худгийн тоо<br>-Засварласан худгийн тоо | - 5 ш<br>- 0 ш<br>- 7500 га | - 2 ш<br>- 2 ш<br>- 6000 га | Улсын төсвийн 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг, Баян-Овоо, Баян-Өндөр, Богд, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр Бууцагаан, Богд, Гурванбулаг, Өлзийт сумын нутагт гүн өрмийн 4 худаг шинээр гаргах буюу сэргээн засварласан. Аймгийн хэмжээнд нийт 8 худаг шинээр гаргаж нийт 12,0 мянган га бэлчээрийг усжуулсан байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.2 | Хүн амын хүнсний хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлэх | /Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал/80.0 сая | Махны нөөцийн хэмжээ/тн | | | Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд нээлттэй төсөл сонгон шалгаруулж орон нутгийн "Баянхонгор констракшн" ХХК-ны Мах март махны үйлдвэртэй 180тн мах нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус аж ахуй нэгж нь Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэнгээр болон гулуузаар хөнгөлөлттэй үнээр худалдаалсан. Явцын хяналтыг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар удирдамжийн дагуу хийж, зөрчил илрээгүй. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8500, үхэр /1кг/ 10500 төгрөгөөр тус тус худалдаалан, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй нөхцөлийг ханган ажиллаж, зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн доогуур ханштайгаар 2023 оны 04 дүгээр сарын 04-өөс 06 дугаар сарын 04 хүртэл худалдаалсан. Гэрээний гүйцэтгэлээр нийт санхүүжилт 80.0 сая төгрөгийг “Баянхонгор констракшн" ХХК-д олгосон. | 100% |
| 6.3 | Хөдөө аж ахуйн кластер төслийг хэрэгжүүлж, үйлдвэрийг ашиглалтад оруулах | 18,0 тэрбум /Улсын төсөв/ | ашиглалтад орсон үйлдвэрийн тоо | -0 | -1 | Хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах төслийг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэн ажиллаж байна. Ингэний сүүгээр нэмүү өртөг шингэсэн, гадаад зах зээлд худалдан борлуулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэн үйлдвэрийн барилгын ажлыг 2021 онд тендер сонгон шалгаруулалт зарлан “Базарь дарь” ХХК шалгаран тус барилгыг барьж 2022 онд үйлдвэрийн барилгыг хүлээлгэн өгсөн. Цаашид тус үйлдвэрийн үйл ажиллагааг Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГазар хариуцан ажиллах бөгөөд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг БНХАУ-д захиалан авчирч угсарсан. Тус төслийн нийт төсөв 3,8 тэрбум. Мах ногооны зоорь, бойны газар | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барих төслийн нийт төсөвт өртөг 3 тэрбум төгрөг бөгөөд тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж “Сант-Өндөр” ХХК шалгарч барилгын ажлыг бүрэн дуусгасан. Хөдөө аж ахуйн цогцолборын үйлдвэрлэлийн бүсийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажилд “Алтай эколос” ХХК, цахилгааны эх үүсвэрийн материал нийлүүлэх ажилд “Эн ди эм эм” ХХК, гадна холбооны шугамын материал нийлүүлэх ажилд “Нью Бест хаус” ХХК тус тус шалгарч дээрхи ажлыг бүрэн дуусган хүлээлгэн өгсөн. Нийт 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. | |
| **Зорилт 7. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжил, геологи, уул уурхайн бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 7.1 | Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой хамгаалалтын эрүүл ахуйн бүсийн хамгаалалтын зураглал хийж баталгаажуулах | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 10.0 | Хамгаалалтын бүсийн зураглал хийж, кадастрын мэдээллийн санд бүртгэсэн сумын тоо | 0 | 20 | Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/72 дугаар захирамжийн дагуу Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай хамтран аймгийн хэмжээнд усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой хамгааллалтын эрүүл ахуйн бүсийн хамгаалалтын зураглалыг ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 7.2 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх | Орон нутгийн хөгжлийн сан 300.0 | Тарьсан модны тоо | 211,828 | 500,000 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/252, А/537 дугаар захирамжийн дагуу хавар, намрын улиралд мод тарих арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд энэ онд суулгацаар 114,316 ширхэг, үрээр болон мөчрөөр 187,623 ширхэг нийт 301,939 ширхэг модыг тарьж, бойжуулж байна. | 100% |
| 7.3 | “Хариуцлагатай уул уурхай-Эдийн засгийн үндэс” сургалтыг уул уурхайн бүхий сумдад зохион байгуулах | Байгууллагын төсөв | Сургалт зохион байгуулсан сумын тоо | 0 | 5 | Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/610 дугаар захирамжийн дагуу “Хариуцлагатай уул уурхай” сургалтыг Баян-Овоо, Өлзийт, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Галуут зэрэг 6 сумдын удирдлага, иргэд бүхий 200 гаруй хүнд зохион байгуулсан. Сургалтаар уул уурхайн салбарын 6 сэдэвт мэдээллийг танилцуулж, иргэдэд уул уурхайн салбарын хууль тогтоомж, эдийн засагт үзүүлж буй зэрэг нөлөөлөл, хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг олгосон. | |
| **Зорилт 8. Зам тээвэр, дэд бүтэц, хот байгуулалт, төлөвлөлт, газрын харилцааны бодлогыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 8.1 | Аймгийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээг нэмэгдүүлэх | - | Газар өмчлүүлсэн иргэдийн тоо | 12112 | 12650 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн "Монгол Улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт" 105 дугаар тогтоолын дагуу аймгийн хэмжээнд нийт 32,65 га газрыг иргэдэд өмчлүүлэхээр батлагдсан. Үүнээс 2023 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 131 иргэнд 8,6 га газрыг эзэмшүүлсэн байна. | 50% |
| 8.2 | Баянхонгор аймагт 35 МВт хүчин чадалтай дулааны станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | Экзим банкны хөрөнгө оруулалт аар | - Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 5% | 40% | Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хот суурин газрын дулаан хангамжийн хүртээмжийг сайжруулах зорилгоор БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 10 аймгийн төвд дулааны станц, шугам сүлжээ барих төслийг 148,0 сая долларын зээлээр хэрэгжүүлэх болсон. ТЭЗҮ боловсруулалтын ажил хийгдэж дууссан. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бьюксан Инженеринг” ХХК, туслан гүйцэтгэгчээр “МЭЗ” ХХК гэрээ байгуулсан. 2022 онд барилгын суурийн ажил дууссан ба хөрс нягтруулалт, шороо | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | булалтын ажил хийгдсэн. Энэ онд дулааны станцын барилгын ган каркасын 1 дүгээр үеийн угсралтын ажил, Конивейер- 1, 2-ын суурь, Бутлуурын барилгын суурь, Нүүрс хүлээн авах барилгын төмөр бетон хийцийн ажил, Утаа сорогчийн барилгын суурь, Цахилгааны барилгын суурь, Харуулын байрны барилгын суурь, Зуух 1, 2, 3 халах гадаргуугын угсралтын ажлууд бүрэн хийгдэж дуусаад байна. Тус төсөл нь 2024 оны 09 дүгээр сард ашиглалтад орно. | |
| 8.3 | Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэх | 8,0 тэрбум Улсын төсвийн | - Гүйцэтгэлийн хувь | 33.5% | 100% | Шинэ суурьшлын бүсийн 10км хатуу хучилттай авто замын зураг төсвийг 2021 онд "Ихэр мөнх" ХХК хийж гүйцэтгэсэн. Тус ажлын тендэр сонгон шалгаруулалт зарлагдаж үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу "Түм дэлгэрэх" ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 7,995,198,327.00 төгрөгний 2022/53 дугаартай гэрээ байгуулсан.<br>Авто замын далангийн ажил 10км газар бүрэн хийгдсэн. Автозамын бүх бордюрыг цутгаж дууссан ба 3.8км газарт бордюр суулгаад байна. | 100% |
| 8.4 | Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийг хийх ажлыг хэрэгжүүлэх | 14,0 тэрбум Улсын төсвийн | - Гүйцэтгэлийн хувь | 0% | 45% | Баянхонгор аймгийн 110/35/6 кВ-ын 12 МВА суурилагдсан чадалтай дэд станцын өргөтгөлийн ажлыг 110/35/10 кВ-ын 36 МВА суурилагдсан чадалтайгаар өргөтгөл хийх ажлын гүйцэтгэгчээр "ДМТМ Трейд" ХХК-тай гэрээ байгуулж ажлыг 2022 онд эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд 5CVG 2ш бүрэн суурьлуулсан. Энэ онд Хаалттай хуваарилах байгууламж, 10кВ-ын 16 МВА суурилагдсан чадалтай трансформаторыг бүрэн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажил нь 2024 оны 08 дугаар сард ашиглалтад орно. | |
| 8.5 | Баянхонгор сумын гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг хэрэгжүүлэх | 27,0 тэрбум Улсын төсвийн | - Гүйцэтгэлийн хувь | 9,5% | 35% | Улсын төсвийн 27,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор сумын Гэр хорооллын шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж "Б софт" ХХК шалгаран гэрээ байгуулж 2022 оны 06 сараас шугам сүлжээний угсралтын ажлыг эхлүүлсэн. Уг төслийн хүрээнд Дулааны шугам 4620 м, Ариутгах татуурга 17100м, Цахилгаан 3800м, Холбоо 2070м, Халаалтын зуух-2ш 15м*30м хэмжээтэй, 1 давхар, УДДТөвийн барилга 12м*9м хэмжээтэй, 1 давхар /2ш/, Бохир усны насос станцын барилга 3.6м*3.6м хэмжээтэй 1 давхар, Дэд өртөөний барилга ХТП2*400 кВа, 2*630 кВа, чадалтай, 6м*9м хэмжээтэй, 1 давхар /6 ширхэг/ ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн. Энэ онд Баянхонгор сумын 2, 3, 6, 7, 9 дүгээр багуудын гэр хорооллолд дулаан, цэвэр, бохир усны шугам ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Тус төсөл 2024 онд ашиглалтад орно. | 100% |
| 8.6 | Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу явган хүний зам хийх | Замын сангийн 220,0 сая төгрөг | -Замын урт /метр/ | 0 | 100% | Баянхонгор аймгийн “Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу явган хүний зам хийх” ажлын тендэр сонгон шалгаруулалт зарлагдаж үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу “Тэнгэрийн уул” ХХК-тай 2023 оны 03-дугаар сарын 14-ний өдөр 219,918,942.0 төгрөгийн 2023/24 дугаартай гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 2664м2 явган зам, 155м2 бетон гарцыг хийж гүйцэтгэн Баянхонгор аймгийн Засаг даргын А/447 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2023 оны 09 | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгээр сарын 06-ны өдөр ашиглалтад хүлээн авсан. | |
| 8.7 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны төсөл, арга хэмжээг төлөвлөх, аймгийн ИТХ-аар батлуулах | - | 2024 оны аймгийн төсөвт Орон нутгийн хөгжлийн сан хавсралтаар батлагдсан байна. | 2024 оны аймгийн төсөвт Орон нутгийн хөгжлийн сан батлагдсан. | Байгуулсан ажлын хэсэг нэгтгэсэн саналыг зөвлөлөөр танилцуулан АИТХурлаар батлуулсан байна. | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан Аймаг нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, зөвлөмж болон Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн өгсөн зөвлөмжийн дагуу боловсруулж Аймгийн ИТХ-д өргөн хүулийн хугацаанд өргөн барьсан. Аймгийн ИТХ-ын 17 дугаар хуралдаанаар хэлэлцэж Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг баталсан. | 100% |
| 8.8 | Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгах саналыг авч нэгтгэн, төсөл арга хэмжээг төлөвлөж, эрэмбэлэн, үнэлж, Улсын төсвийн цахим системд оруулан, холбогдох яамдад хүргүүлэх, батлуулах | - | Аймаг орон нутагт хэрэгтэй бүтээн байгуулалтын томоохон ажлууд 2024 оны Улсын төсөвт батлагдсан байна. | Аймаг орон нутагт хэрэгтэй бүтээн байгуулалтын томоохон ажлууд 2024 оны Улсын төсөвт батлагдсан байна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ажлуудын саналыг сум, байгууллагуудаас авч нэгтгэн, яамдууд руу хүргүүлж, | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг холбогдох байгууллага, сумдаас хүлээн авч нэгтгэн, ажлын хэсгээр үнэлж, эрэмбэлэн нийт 50 төсөл, арга хэмжээг холбогдох хууль журамд нийцүүлэн төлөвлөж 05 дугаар сарын 01-ний дотор Төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр болон албан бичгээр холбогдох яамдад хүргүүлсэн. Их засвар, тоног төхөөрөмжийн саналыг байгууллага, сумдаас авч нэгтгэж явуулснаас 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 93 тэрбум 247.1 сая төгрөгийн 23 төсөл арга хэмжээг батлагдсан. 2024 онд нийт 43 тэрбум 176.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор улсын төсөвт туссан байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын төсөвт батлагдсан байна. | | |
| **Зорилт 9: Соёлын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, өсвөр үе залуучуудад сурталчлан таниулах, соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулах** | | | | | | | |
| 9.1 | Түүх соёлын дурсгалт газар, соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчдыг илрүүлэх, сурталчлах, дэмжихэд чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулах | 14.0 сая | Оролцогчдын тоо | 315 | 100 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 264 дүгээр тогтоолоор “2023-2025 оныг Монголд зочлох” жил болгон зарласантай холбогдуулан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд 84 хүний бүрэлдэхүүнтэй оролцсоноос 44 соёлын өв тээгч, уран бүтээлчид 7 ай савын хүрээнд өв соёлоо сурталчлан шилдгийн шилдгээр шалгарч, “Алтан цом” батламж авсан. Урлагийн олон талт арга хэмжээг хүргэсэн. Уртын дууч Ч.Намжилын нэрэмжит уртын дууны улсын уралдааныг аймагт зохион байгуулж 16 оролцогчийг хамруулан төв халхын уртын дууг сурталчилсан.“Соёлын бүтээлч сар аян”-ы хүрээнд соёл урлагийн 23 байгууллага, 19 сумын Соёлын төвөөс нийт 120 арга хэмжээг /соён гэгээрэл, мэдлэг түгээх сургалт арга хэмжээ 17, Урлагийн тоглолт, үзвэр үйлчилгээ 41, бүтээлч залуусыг дэмжих уралдаан тэмцээн 39, музей галерейн үзэсгэлэн 23/ зохион байгуулж 21608 хүнд хүрч үйлчилснээс 12102 хүүхэд, 222 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд соёл урлагийн олон талт арга хэмжээг хүргэсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны 355-р дугаар захирамжаар “Хээрийн судалгаа шинжилгээ хайгуул хийх ажлын хэсэг байгуулах тухай” түүхийн дурсгалт газар, түүхийн болон байгалийн үнэт олдвор нээж илрүүлэх ажлыг хийж байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9.2 | Аймгийн зохиолчдын "Хонгорын дуун" утга зохиолын өдөрлөг зохион байгуулах | 5.0 сая | Оролцогчдын тоо | 43 | 112 | "Хонгорын дуун" утга зохиолын өдөрлөг зохион байгуулагдаж, Улаанбаатар, Баянхонгор, Ховд, Завхан, Говь-Алтай, Өвөрхангай, Дархан-Уул, Булган, Архангай, Төв аймаг нийт 10 аймгаас 61 яруу найрагч оролцож шагналт байр 5, тусгай байр 2 -ыг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. | 100% |
| 9.3 | Заг, Байдрагийн хүрэн бэлчирт Монгол туургатны харвуул их наадам зохион байгуулах | 50.0 | Оролцогчдын тоо | 380 | 400 | Монгол туургатны харвуул их наадам"-ыг Заг сумын нутаг Хүрэн бэлчирт уламжлалт /зэвт/ харваа, сарамбай харваа, бөмбөг намнах харваа, холч харваа, нийт 6 төрлийн харваагаар зохион байгууллаа. Наадамд 14 аймгийн давхардсан тоогоор 780 гаруй харваачид, ОХУ-ын Буриад улсаас 3, ӨМӨЗО-ны 10 харваач оролцсон. Арга хэмжээг зохион байгуулахад аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 30.0 сая, хандив тусламжаар 50.0 сая нийт 80.0 төгрөгийг зарцуулсан. | 100% |
| **Зорилт 10: Хүүхэд, залуучуудын эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлж, Монгол ахуй, ёс заншил, өв уламжлал, хэл бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 10.1 | Иргэдийн боловсролыг дээшлүүлэх, Төрийн албан хаагч, иргэдийн үндэсний бичгийн ур чадварыг сайжруулах, төрийн албыг үндэсний бичиг эрхлэх бэлтгэлийг хангах | 10.0 сая | Оролцогчдын тоо | 15000<br>1<br>дунд | 15000<br>2<br>ахисан | Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн албыг үндэсний бичгээр эрхлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор "Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах зардал олгох тухай" аймгийн Засаг даргын 2023 оны А/273, А/274 дугаар захирамжуудаар хөрөнгийг шийдвэрлэж, "Хос бичигтэн-Төрийн байгууллага" шалгаруулах болзолт уралдааныг 3 үе шаттай зохион байгууллаа. | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10.2 | Шинжлэх ухаан технологийн аймгийн зөвлөл судалгааны баг ажиллуулж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, шинэ патент, грант олгох | 10.0 сая | Шинэ патент, грантын тоо | 0 | 5 | Аймгийн Засаг даргын "Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, зөвлөлийн дүрэм батлах тухай" 2023 оны А/196 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, Хоёрдугаар хавсралтаар Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн дүрэм-ийг тус тус баталсан. Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 90 хувь биелж, БШУЯ-наас зарласан грант олгох уралдаан Хангайн бүсэд Баянхонгор аймаг дахь Өлзийт Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн "Шингэн бордоо" шалгарч 20. 0 сая төгрөгийн грант авлаа. | 90% |
| 10.3 | “Судлаач хүүхэд” клубын үйл ажиллагааг дэмжих, удирдлага арга зүйгээр хангах | АЗДТГ-ын төсөв | Зорилтот судалгааны тайлан зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 3<br>70% | 3<br>80% | “Судлаач хүүхэд” клубийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг хүүхдийн өөрөө удирдах байгууллагын онцлог, судалгаа хийх арга зүйн талаар мэдээлэл өгөх сургалтад 8 хүүхэд оролцсон. “Судлаач хүүхэд” клуб нь Хүүхдийн эрхийн тухай, хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд үүрэг хүлээгчдийн биелэлт, Хүүхдийн ус уух орчин, хорт зуршлын хэрэглээ, хүүхдийн тоглоомын талбайн стандарт хэрэгжилт, сургууль орчмын хүүхдийн зорчих хэсгийн авто замын гарц, аюулгүй байдал, иргэдийн баруун гарын дүрмийн дадал, хэвшил, электрон тамхины худалдан борлуулалт, спорт заал танхимын ашиглалт, эрүүл ахуй, аюулгүй байдлын судалгаа хийж, үр дүн үүрэг хүлээгчдэд хүргүүлэн ажилласан. Судалгааны ажил хийсний үр дүнд санхүүжилт нэмэгдүүлж орчины тохижилт | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдсэн, шийдвэр гаргагчид, сургуулийн захирлуудын оролцоо манлайлал 20 хувиар нэмэгдсэн | |
| 10.4 | “Хүүхдийн экспо” зохион байгуулах | 3.0 сая Засаг даргын нөөц | Экспод оролцогсдын тоо | 160 | 200 | “Би ирээдүйн баялаг бүтээгч” хүүхдийн экспо үзэсгэлэн худалдаанд 18 сумын ерөнхий боловсролын сургууль, Политехник коллежийн 59 хүүхэд өөрсдийн гараар хийсэн 1050 бүтээлээр үзэсгэлэн гаргаж 1.617.000 төгрөгний борлуулалт хийсэн. Үзэсгэлэнг 260 гаруй хүүхэд үзэж сонирхохоос гадна төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл, иргэд үзсэн. | 100% |
| **Зорилт 11: Хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлж, боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх** | | | | | | | |
| 11.1 | Бага насны хүүхдийн цогц хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 10.0 сая | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 35 хувь | 45 хувь | “Бага насны хүүхдийн цогц хөгжлийн стратеги”-г хэрэгжүүлэх зорилгоор “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г 5 зорилт 25 арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь.Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10.0 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| 11.2 | Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 10.0 сая | Сурлагын амжилт, чанарын өсөлтийн хувь | 41 хувь | 50 -иас дээш хувь | ЕБС-ийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний төлөвлөгөө”-г 5 зорилт, 26 арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 90.7. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10.0 сая төгрөг зарцуулсан. Боловсролын үнэлгээний төвөөс 2023 онд зохион байгуулсан багшийн болон байгууллагын үнэлгээгээр 18 судлагдахууны сурлагын ахиц | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дунджаар 9.6 хувиар өссөн. | |
| 11.3 | "Чадварлаг багш" арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх | 40.0 сая | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 30 хувь | 60 хувь | "Чадварлаг багш арга хэмжээний төлөвлөгөө"-г 1 зорилт 9 арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 40.0 сая төгрөг зарцуулсан. | 90% |
| 11.4 | Боловсролын байгууллагын шинээр болон их засвар ажилд хяналт тавих хүлээн авах ажлын хэсэгт ажиллах | Улсын болон орон нутгийн, бусад эх үүсвэр | Шинэ барилга 2<br>Их Засвар 18 барилга | 13 | 20 | Гурванбулаг сумын сургуулийн барилга 100, Шаргалжуут тосгоны сургуулийн барилгын ажил 70, Баян-Овоо сумын сургуулийн дотуур байр 90, Баянцагаан, Заг, Галуут сумын сургуулийн их засвар 90 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Заг, Баянговь сумын сургуулийн дотуур байр, Баянхонгор сумын 4, 5, 11, 12 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар, Бууцагаан, Богд, Баян-Өндөр, Баацагаан сумын цэцэрлэгийн барилгын гадна их засвар 100 хувь хийгдэж Улсын комисс хүлээн авсан. Шинээр 2 барилга, их засвар 13, нийт 16 барилга, байгууламжийн явцад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажилласан. | 90% |
| **Зорилт 12: Аймгийн хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 12.1 | Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан эрт илрүүлэг үзлэгийг чанаржуулах | Эрүүл мэндийн даатгалын сан 3000.0 | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь | 9.3 | 30 | Хүн амын эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх оношилгоонд хамрагдалт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 24381 иргэн буюу 27.2 хувьтай улсын хэмжээнд 17 дугаарт байсан бол эрчимжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулснаар эхний 11 сарын байдлаар 30243 иргэн хамрагдаж, 33.7 хувь болон нэмэгдэж, улсын хэмжээнд 12 дугаар байранд байна. Манай аймгийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт улсын дундажаас | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3.4 хувиар, аймгуудын дундажаас 0.9 хувиар бага байна. Насны ангиллаар авч үзвэл: 0-17 насанд аймгийн дунджаас 5.9 хувиар бага улсын дунджаас 2 хувиар их, 18-45 насанд улс аймгийн дунджаас 4 хувиар бага, 46-аас дээш насанд аймгийн дунджаас 9 хувиар их улсын дунджаас 4 хувиар бага үзүүлэлттэй байна. Өвчлөлөөр нь авч үзвэл 0-17 насанд шүдний өвчлөл, 18-34 насны иргэдэд бөөр шээс дамжуулах замын эмгэг, цөсний үрэвсэл, ходоодны өнгөц үрэвсэл, 35-64 насны иргэдэд цөсний замын эмгэг, бөөр шээс дамжуулах замын эмгэг, дотоод шүүрлийн эмгэг, ходоодны өнгөц үрэвсэл зонхилон тохиолдож байна. | |
| 12.2 | "Жаргалтай амьдрал төв"- ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | Орон нутгийн төсөв 100.0 сая | Үйлчлүүлэгчийн тоо | 120 | 150 | Тус төвөөр 2023 онд 84 үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлж, архинд донтох эмгэгээр хүндэрсэн 45 үйлчлүүлэгчийг Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагт хэвтүүлэн эмчилсэн. Донтолтын тусламж үйлчилгээний үр дүн 75 хувьтай байна. Сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний "Жаргалтай амьдрал" төвд нэмэлт санхүүжилт олгох тухай Аймгийн Засаг даргын 2023 оны А/385 дугаар захирамжаар 100.0 сая төгрөгийг олгож, 2023 оны үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэн, тасралтгүй хэвийн ажилласан. | 100% |
| 12.3 | Эрүүл мэндийн салбарын "Эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн бодлого төлөвлөлт" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | 32.0 сая | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 85 | Эрүүл мэндийн салбарын "Эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн бодлого төлөвлөлт" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/580 дугаар захирамжаар батлан, хэрэгжилтийг зохион байгууллаа. Уг. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөний хүрээнд Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай эмч мэргэжилтнийг бэлтгэх тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/552 дугаар захирамжаар Анхан шатны эрүүл мэндийн удирдлага, Эрүүл мэндийн бодлого, удирдлага, Талбарын тархвар судлал, Нийгмийн эрүүл мэндийн судлаач, эрүүл ахуйч, Анатомийн эмгэг судлал, Эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдал, сувилагч, бага эмч зэрэг 8 мэргэжлээр 30 хүнийг сургахаар сургалтын байгууллагуудтай гэрээ хийж, төлбөрийн дэмжлэгийг үзүүлсэн. Эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах ажлын байрны тасралтгүй сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай | 90% |
| 12.4 | "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | 20.0 сая | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 0 | 85 | "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/271 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж байгаа үндэсний хөдөлгөөний зорилго зорилтот нийцүүлэн, харъяа салбар байгууллагуудаас 2 удаагийн санал авч нэгтгэн, "Эрүүл иргэн–Хонгорын баялаг" арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргын 2023 оны А/554 дүгээр захирамжаар батлан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Арга хэмжээний төлөвлөгөөний дагуу анхан болон хоёрдогч шатлалын 26 эрүүл мэндийн нэгж Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг зохион байгуулж, Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээ, Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрүүдийн хүрээнд 2023 оны 11 сарын байдлаар 26 тэмдэглэлт өдрийг зохион байгуулж, аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 52289 иргэнийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаанд хамруулсан. Үүнээс сургуулийн өмнөх насны- 2580 /4.9%/, Өсвөр насны хүүхэд- 6216 /11.9%/, Оюутан- 2050 /3.9%/, Албан хаагч- 5768 /11.4%/, Малчин иргэд- 10192 /19.5%/, Ажилгүй иргэд- 3515 /6.7%/, Хувиараа хөдөлмөр эрхлэгчид- 6877 /13.1%/, Бусад- 14968 /28.6%/ иргэн хамрагдсанаас, мэдлэгийн түвшин 56.5 хувиар нэмэгдсэн. "Түмэн дасгал" буюу япон хүн бүрийн эрүүл амьдралын үндэс болсон тайсо-дасгалыг 18 албан байгууллага, 3 суманд зааж сурган, 7 байгууллага, 8 сум ажлын байрны дасгалыг хийж хэвшүүлээд байна. | |
| **Зорилт 13: Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжил, хамгааллыг сайжруулах** | | | | | | | |
| 13.1 | Хуримын ордныг түшиглэсэн Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийг байгуулах | Байгууллагын төсөв | Төвөөр үйлчлүүлэгчдийн тоо | 0 | 150 | Хуримын ордныг түшиглэн "Гэр бүлийн зөвлөгөө өгөх" төвийг стандартын дагуу орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр байгуулж, 129 иргэнд зөвлөгөө мэдээлэл, ганцаарчилсан уулзалт хийснээс 53 хүүхэд, 35 насанд хүрэгчид, 21 гэр бүл хамрагдсан байна. Хүйсээр ангилбал 48 нь эрэгтэй, 81 нь эмэгтэй байна.<br>Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан иргэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.4 хувиар, гэр бүл цуцлалт 39.7 хувиар буурсан. | 100% |
| 13.2 | "Хонгорын гэр бүл" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 65 | 75 | "Хонгорын гэр бүл" арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг 2 зорилт 24 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг бүх насны иргэдэд амьдралын мөчлөг, насны онцлогт нь тохирсон байдлаар үе шаттайгаар зохион байгуулж нийт 2735 хүнд хүрсэн байна. Сургалтад хамрагдсан иргэдийг хүйсээр ангилвал эрэгтэй 952, эмэгтэй 1783 байна. "Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв"-ийн үйл ажиллагааг эхлүүлж, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөнд 162 иргэн үйлчлүүлсэн байна. Арга хэмжээний хэрэгжилтийг хангахад орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг зарцуулсан. | |
| 13.3 | Зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулах | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Ажлын байранд зуучилсан иргэдийн тоо | 2400 | 2500 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний ганцаарчилсан зөвлөгөөнд зорилтот бүлгийн 105 /үүнээс эмэгтэй 78/ иргэнд зөвлөгөө өгч, 97 иргэнийг түр ажлын байранд зуучилсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний бүлгийн зөвлөгөөнд 8 удаа 364 иргэн хамрагдаж, мэдээлэл, зөвлөгөө авч түр ажлын байранд зуучлагдсан. | 70% |
| **Зорилт 14: Сэтгэл хангалуун амьдрах нөхцлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг нэмэгдүүлж, эрүүл, идэвхитэй амьдралыг бий болгох** | | | | | | | |
| 14.1 | Хүүхдийн төлөө зөвлөл, Залуучуудын хөгжлийн зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах | Засаг даргын нөөц | Төлөвлөгөөний биелэлтийн дундаж хувь | 75 | 85 | Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 19 ажил, арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 4 удаа хуралдаж 78 хүүхдэд өмгөөлөл, хууль эрх зүй, сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлсэн. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 2 хүүхдийн хугацаа дууссан ба 8 хүүхдийг "Хүүхдийн эрх ба хууль эрх зүйн ойлголт, мэдлэг", "Стресс ба түүнээс урьдчилан сэргийлэх нь", Жендэр ба жендэрээс үүдэлтэй хүчирхийллээс | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтуудад хамруулсан. Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 21 ажил, арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Салбар хорооны хурлыг 2 удаа цахимаар 2 удаа танхимаар зохион байгуулсан.<br>Жендэрийн үндэсний хороо, аймгийн салбар зөвлөл хамтран 5 аймгийн 30 албан хаагчийг хамруулан анхан шатны сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, аймаг тус бүрээс 2, Баянхонгор аймаг 9 сургагч бэлтгэж, чадавхжуулсан.<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь 75, тайлагнах хугацаа болоогүй. | |
| 14.2 | Монголын хүүхдийн спортын VII наадам зохион байгуулах | 80.0 сая | Оролцогчдын тоо | 0 | 7000 | Монголын Хүүхдийн спортын зуны VII наадмыг "НӨХӨРЛӨЕ, ХӨГЖЬЕ, ХАМГААЛАЯ" уриан дор зохион байгууллаа. Наадамд 21 аймаг, 9 дүүргээс 5000 гаруй өсвөрийн тамирчин спортын 23 төрлөөр 197 жин зайд 1500 медалийн төлөө авхаалж самбаа ур чадвар, хүч чадлаа сорин өрсөлдөж, шилдэгүүдээ тодруулсан. Орон нутгийн 70 гаруй төрийн болон төрийн бус байгууллага, 3600 гаруй албан хаагч, боловсролын салбарын 29 сургууль, 36 цэцэрлэгийн албан хаагчид хамтран ажилласан.<br>Ерөнхий боловсролын 8 сургууль / 2449/, 11 цэцэрлэг /991/ 19 байршилд 21 аймаг 9 дүүргийн 3440 багш дасгалжуулагчид, наадамд урилгаар оролцсон 250 гаруй хүндэт зочид, албаны хүмүүс, 300 гаруй шүүгчдэд байр хоолоор үйлчилж, тусгай хүчний алба хаагчид аюулгүй байдлыг хангах, сайн дурын хэтчээр 113 хүүхэд орон нутгаа сурталчилах, наадам болж | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | буй заал талбайд чиглүүлж, хүргэх, эрүүл мэндийн салбарын эмч, ажилтанууд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэн хамтран ажилласан. | |
| 14.3 | Улс тив дэлхийн тэмцээнд амжилт үзүүлсэн тамирчдад дэмжлэг үзүүлэх | 57.0 сая | Дэмжлэг үзүүлсэн тамирчдын тоо | 3 | 6 | Монгол Улсын харцага Н.Золбоо, Б.Эрдэнэхүү, улсын начин Э.Батмагнай, С.Энхтөр нарт тус бүр 20.0 сая, нийт 80.0 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тайланд улсад зохион байгуулагдсан бодибилдинг фитнесийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон тамирчин Ж.Сарнай, Э.Анхзаяа, Н.Нэмэхбаяр нарт тус бүр 10.0, нийт 30.0 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. | 100% |
| 14.4 | Клубуудын Улсын аварга шалгаруулах волейболын тэмцээн зохион байгуулах | 20.0 сая | Оролцогчдын тоо | 0 | 250 | Клубүүдийн аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй 4, эмэгтэй 6 багийн 160 тамирчид оролцож, волейболын спортыг сурталчилсан арга хэмжээ боллоо. | 100% |
| 14.5 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | 1500 | 1800 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 3029 иргэн хамрагдаж 1,668,1 сая төгрөгийг зарцуулж 1751 байнгын болон түр ажлын байр гарсан байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан хүний тоо өмнөх оноос 5.9 хувиар өсөж, ажилгүйдлийн түвшин 2022 онд 15.5 хувь байсан бол 2023 онд 9.5 хувь болж 6 хувиар буурсан. | 100% |
| 14.6 | Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангасан байх | 1.0 сая | Сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоо | 6180 | 6380 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалаа.<br>Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч ажил хөдөлмөр эрхэлдэггүй 4877 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даатгалд, 0-3 настай хүүхдээ асарч буй эх 108, нийт 4985 иргэний сайн дурын гэрээг байгуулж, шимтгэлийг санд төлүүлсэн. Даатгалд хамрагдсан 4985 даатгуулагчийн хамрагдалтыг ажил хөдөлмөр эрхлэлтийн төрлөөр авч үзвэл малчид 3358, хувиараа хөдөлмөр эрхлэгч 968, ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 295, оюутан 83, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 108 байна. Сайн дурын даатгалд шинээр 372 иргэн хамрагдсан нь өмнөх оноос 114 хүнээр буюу 30.6 хувиар өссөн. | |
| 14.7 | Нийт тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах | 7.5 сая | Цахимжсан хувийн хэргийн тоо | 0 | 12877 | Аймгийн хэмжээний нийт 12851 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг бүрэн цахимжуулсан. Дээрх ажилд аймгийн Засаг даргын А/122 дугаартай "Тэтгэвэр авагчийн хувийн хэргийг цахимжуулах ажилд хөрөнгө зарцуулах тухай" захирамжаар 7.500.00 төгрөг зарцуулсан. | 100% |
| **Зорилт 15: Санхүү, эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарах, Төрийн бүтээмжийг сайжруулах, албан хаагчдыг тогтвортой ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 15.1 | Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн нэгдсэн шалгалтыг 4 суманд зохион байгуулах | Байгууллагын төсөв | Нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулсан сумын тоо | 13 сум | 17 сум | Аймгийн Засаг даргын А/269 дүгээр захирамжаар хяналт шалгалт хийх удирдамжийг гарган Хүрээмарал, Заг, Гурванбулаг, Галуут сумдад удирдамжийн дагуу ажиллаж нийт 40 гаруй албан хаагчдад санхүүгийн чиглэлийн зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. | 100% |
| 15.2 | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийг шинэчлэх | Байгууллагын төсөв | Идэвхгүй тээврийн хэрэгслийн хасалт хийсэн тоогоор | 23943 | 23443 | Зам Тээврийн Хөгжлийн Сайд,Сангийн Сайдын хамтарсан 2023 оны А/57/48 дугаартай тушаалын дагуу Баянхонгор аймгийн Засаг Даргын 2023 оны А/157 тоот захирамж гарч аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж ажиллалаа. 2023 онд сүүлийн 1-4 жилийн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд техникийн хяналтын үзлэгт ороогүй, татвар төлөөгүй нийт 6,839 автомашин, мотоцикл тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлд хамруулах судалгаа гарсан. Улсын бүртгэлээс 287 тээврийн хэрэгслийг хасалт хийлгэсэн, 2239 тээврийн хэрэгслийн хасалт хийлгэх хүсэлтийг иргэдээс хүлээн авч тооллого зохион байгуулах ажлын хэсэгт хүлээлгэн өгч жагсаалтаар хасалт хийлгүүлсэн. | |
| 15.3 | “Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем”-ийг цахим хэлбэрт шилжүүлэх | Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 10.0 | Төрийн сангийн гүйлгээний цахим нэвтрэлтийн хувь | 20 | 80 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/31 дүгээр захирамжаар аймгийн хэмжээнд төрийн сангийн 21 нэгжийн 189 төсөвт байгууллагуудын төлбөр тооцоо “Төрийн сангийн удирдлагын цахим систем”-д 100 хувь амжилттай шилжсэн. | 100% |
| 15.4 | Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн аймгийн үзлэг зохион байгуулах | Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 12.0 | НББ хөтлөлтийн хувь | 80 | 90 | Аймгийн засаг даргын А/209 дүгээр захирамжаар Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн аймгийн үзлэгийг удирдан зохион байгуулах комиссыг нэгдүгээр хавсралтаар бүртгэл хөтлөлтийн үзлэг явуулах төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар батлуулж төлөвлөгөөний дагуу:<br>1.Шинээр томилогдсон эд хариуцагч нарыг сургалтад хамруулж 21 эд хариуцагчийг үнэмлэхтэй болгосон<br>2.Аймгийн төвийн төсвийн байгууллагын нягтлан бодогчдын дунд төрийн сангийн цахим шилжилттэй холбоотой “АСТ” тэмцээн нийт 76 нягтлан бодогч, санхүүчид оролцож цахим төрийн сангийн цахим шилжилттэй холбоотой | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл сайн болсон. 3.Сумдын Санхүүгийн албаны дунд зарласан "Цахим санхүүгийн алба" уралдааныг дүгнэсэн<br>4. Нягтлан бодогчдын судалгааг шинэчилсэн.<br>Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд 156 нягтлан бодогч, санхүүгийн ажилтан хамрагдаж төрийн сангийн цахим шилжилттэй холбоотой хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл сайжирсан. | |
| **Зорилт-16. Татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулах замаар татварын суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийг бууруулан, улс орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 16.1 | Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд татвар төлөгчдийг бүрэн холбох, төлбөрийн баримт олголтын хувийг 90-ээс дээш хувьд хүргэх | Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 5,0 | Төлбөрийн баримт олголтын хувь | 65 | 90 | Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээ, аймгийн Засаг даргын 2023 оны А/208 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах, НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Татварын хэлтэстэй хамтран аймагт худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэн аж ахуй нэгжийн Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд холбогдсон, холбогдоогүй татвар төлөгчдийн судалгааг сум тус бүрээр нарийвчлан гаргаж, явуулж байгаа эсэх байдалд хяналт тавьж, мэдээллийг шинэчлэн, татвар төлөгчдийн бүртгэлд нэмэх, хасах ажлыг гүйцэтгэж байна.<br>Аж ахуйн нэгж, иргэдийг сегментээр ангилж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн танхимын 6, цахим 4 удаагийн сургалтад нийтдээ 116 татвар төлөгчийг хамрууллаа. | 100% |
| **Зорилт 17: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гарч буй үр дүнд үнэлгээ өгч, хүндрэл, бэрхшээл, тасалдлыг арилгаж, бодит үр дүн, үр нөлөөтэй байдлаар хэрэгжих таатай нөхцөл бүрдүүлэх** | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17.1 | Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах ажлыг зохион байгуулах | - | -цахим системд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо<br>-Засгийн газарт тайлагнасан тайлангийн тоо<br>-Хэрэгжилтийн хувь | тайлангийн хэрэгжилт-66.67 хувь | Хэрэгжилтийг 25 хувиар нэмэгдүүлэх | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сар бүр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын unelgee.gov.mn цахим санд тайлагнасан. Аймгийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг unelgee.gov.mn цахим системд 94.71 хувийн хэрэгжилттэй тайлагнасан. Энэ нь өмнөх оны мөн үеэс 28.04 хувиар ахисан үзүүлэлт юм. | 100% |
| 17.2 | Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | | -цахим системд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо<br>-Засгийн газарт тайлагнасан тайлангийн тоо<br>-Хэрэгжилтийн хувь | тайлангийн үнэлгээ 59.81 хувьтай | 29 байгууллага, 6 нэгжийн тайланд үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн байх Засгийн газарт журмын дагуу нэгдсэн тайланг хүргүүлсэн байх | Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар тайлагнасан 28 байгууллага, 6 нэгжийн тайлан болон нэгдсэн тайланд үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн.<br>Засгийн газрын хэрэг эрхлэх газарт журамд заасан хугацааны дотор буюу 2023 оны 03 дугаар сарын 01-ний дотор тайлагнасан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 87.05 хувийн хэрэгжилттэй байна. Энэ нь өмнөх оноос 27.24 хувиар өссөн дүн юм. | 100% |
| 17.3 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч, үнэлэх | | - цахим системд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо<br>-Засгийн газарт тайлагнасан тайлангийн тоо<br>-Хэрэгжилтийн хувь | 45 байгууллага, 5 нэгжийн | 53 байгууллага, 5 нэгжийн 2023 оны | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2022 оны жилийн эцэс болон 2023 оны эхний хагас жилийн байдлаар тус бүр 53 байгууллагын тайланд, мөн нэгдсэн тайланд 2 удаа, нийт 108 удаагийн хяналт | 100% |

| | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн хэрэгжилт 54.89 хувьтай | эхний хагас жилийн хэрэгжилтийн цахим тайланг үнэлж, зөвлөмж өгсөн байх | шинжилгээ, үнэлгээг хийж, илтгэх хуудас, дүгнэлт, зөвлөмжийг байгууллага тус бүрт нь хүргүүлэн ажиллалаа. 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн дунджийг 2022 оны жилийн эцсийн дундаж хэрэгжилттэй харьцуулж үзэхэд сумдын хэрэгжилт 66.4 хувь болж 4.64 хувиар өссөн, агентлагуудын хэрэгжилт 81.42 хувь болж 8.58 хувиар буурсан байна.<br>2022 оны жилийн эцсээр 186 заалтын хэрэгжилтийг 89.35 хувьтай дүгнэн, жилийн эцсийн тайланг Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан. | |
| 17.4 | Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | | -цахим системд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо<br>-Засгийн газарт тайлагнасан тайлангийн тоо | 39 байгууллага, 7 нэгжийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн хэрэгжилт 48.83 хувьтай | 53 байгууллага, 5 нэгжийн цахим тайланг үнэлж, зөвлөмж өгсөн байх Хэрэгжилтийн хувь ахисан байх | Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг жилийн эцсийн байдлаар тайлагнасан 49 байгууллага, 7 нэгжийн тайлан, аймгийн нэгдсэн тайлан, нийт 57 тайланд үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн. Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2022 оны жилийн эцсийн тайланг журамд заасан хугацааны дотор 90.55 хувийн хэрэгжилттэй тайлагнасан бөгөөд энэ нь өмнөх оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтээс 6.55 хувиар өссөн дүнтэй байна.<br>Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн нэгдсэн тайлан болон 52 байгууллага, нэгжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан зөвлөмжийг 2023 8/1032 дугаар албан бичгээр Засаг даргад, байгууллага, нэгж тус бүрт зөвлөмж хүргүүлсэн. | 100% |
| 17.5 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам | | -Журмын өөрчлөлт батлагдсан байх | | Журамд нэмэлт | Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан. “Аймгийн засаг даргын тамгын газрын нэгж, агентлаг, сумдын засаг даргын | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэн батлах тухай" захирамжид өөрчлөлт оруулах | | | | өөрчлөлт оруулж баталгажуулсан байх | тамгын газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам" -д аймгийн Засаг даргын 2023 оны А/05 дугаар захирамжаар нэмэлт өөрчлөлтийг оруулан сумын Засаг даргын Тамгын газар, агентлагуудын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг гаргахад тус заалтуудыг хэрэгжүүлэн ажиллав. | |
| **Зорилт-18. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гарч буй үр дүнд үнэлгээ өгч, хүндрэл, бэрхшээл, тасалдлыг арилгах, бодит үр дүнг нэмэгдүүлэх, үр нөлөөтэй байдлаар хэрэгжих таатай нөхцөл бүрдүүлэх.** | | | | | | | |
| 18.1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнах ажлыг зохион байгуулах | | -Засгийн газарт тайлагнасан тайлангийн тоо<br>-Хэрэгжилтийн хувь | хэрэгжилт 74.85 хувьтай | | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жил, сарын 8 тайлан, нэмэлтээр нээгдсэн Хууль, УИХ, УИХБХ-ны тогтоолын 3 дугаар улирлын тайлан зэрэг нийт 11 нэгдсэн тайлан болон давхардсан тоогоор 493 байгууллага, 63 нэгжийн, 556 тайланд үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилласан.<br>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд 10 тайлан, нэмэлтээр 2 тайлан, нийт 12 тайланг хугацаанд нь тайлагнасан.<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилт 79.24 хувь үнэлэгдсэн бол 2023 оны 11 сарын байдлаар 85.32 хувь болж өссөн байна. | 100% |
| 18.2 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнүүлж Иргэдийн | | цахим системд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо<br>-Хэрэгжилтийн хувь | хэрэгжилт 59.43 хувьтай | 32 байгууллага, 5 нэгжийн цахим | 2022 оны жилийн эцэст 55 байгууллага аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 33 тогтоолын 66 заалтыг хяналтад авч ажилласан ба 25 байгууллага хугацаандаа тайлагнаж 4 байгууллага тайлан хоцроосон, 26 байгууллага тайлагнаагүй байна. Хэрэгжилтэд хяналт | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд хүргүүлэх | | | | тайланд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх, -Хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлсэн байх | шинжилгээ, үнэлгээ хийхэд 86.67 хувьтай хэрэгжсэн байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар 53 байгууллага 57 тогтоолын 62 заалтыг хяналтад авч ажилласан ба 40 байгууллага хугацаандаа тайлагнаж 10 байгууллага тайлан хоцроосон, 3 байгууллага тайлагнаагүй, аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийн дундаж хувь 79 хувьтай хэрэгжсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19 хувиар өссөн байна. | |
| 18.3 | Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах ажлыг зохион байгуулах. | Байгууллагын төсөв | цахим системд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо -Хэрэгжилтийн хувь | хэрэгжилт 64.32 хувьтай | Хэрэгжилтийг 15 хувиар нэмэгдүүлсэн байх | Тайлант 2022 онд захирамж, албан даалгаврын 382 заалтын хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаар хүлээн авсан бөгөөд хэрэгжилт 93.11 хувьтай үнэлэгдсэн. 2023 оны хагас жилээр захирамж, албан даалгаврын хяналтад авсан 234 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 77,54 хувьтай байсан ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хэрэгжилтийн хувь 13 хувиар ахисан байна. | 100% |
| 18.4 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | | -Зөвлөмжийн тоо -Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 2022 оноос зөвлөмжийг бүртгэлжүүлж,хэрэгжилтийг тооцож эхэлсэн. | -2023 оны зөвлөмжийг бүртгэлжүүлж, хэрэгжилтийг тооцож ажилласан байх | Нутгийн захиргааны байгууллагуудын 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг тус тус 6 хэлтэс, 20 сум, 23 агентлаг, 10 ОНӨБ байгууллагад хүргүүлэн үр дүнг тооцож ажилласан. Энэ онд нийт 110 зөвлөмжийг холбогдох байгууллага, нэгжид хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан. | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 19: Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, зөвлөмжөөр хангах замаар төрийн бодлого шийдвэрийг анхан шатны нэгжид бүрэн хэрэгжүүлэх** | | | | | | | |
| | | | | | | | |
| 19.1 | Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | - | -хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд байрлуулсан гэрээний тоо<br>-цахим системд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо<br>-Засгийн газарт тайлагнасан тайлангийн тоо | Аймгийн Засаг дарга Засгийн газрын 18 гишүүнтэй байгуулсан гэрээг аймгийн цахим санд бүртгэж, хагас бүтэн жилээр тайланг хүлээн авч үнэлсэн. | -25 байгууллага, 7 нэгжийн аймгийн Засаг даргын Засгийн газрын гишүүнтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх | Засгийн газрын гишүүнтэй аймгийн Засаг даргын 2022 онд байгуулсан 19 гэрээг unelgee.gov.mn цахим системд шивж, хэрэгжилтийг тайлагнасан. Аймгийн bayankhongor.igovernment.mn цахим системээр тайлагнасан гэрээг 22 байгууллага, нэгжийн 2022 оны жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>Аймгийн Засаг даргын Засгийн газрын гишүүдтэй байгуулсан 2023 оны 19 сайдын гэрээг цахим системд бүртгэж, хуваарилан, 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнасан 22 байгууллага нэгжийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | 100% |
| 19.2 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байгууллагын тоо<br>-Засгийн газарт аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, | | | Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайланг хугацаанд нь хүргүүлсэн эсэх | | | Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн тайланг Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг 94.57 хувиар дүгнэсэн. Сум, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн нийт 53 байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланд 2023 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар агентлагуудын гүйцэтгэлийн тайлангийн дундаж үнэлгээ 90.79 хувь, Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын тайлангийн дундаж үнэлгээ 84.76 хувь байна. | |
| 19.3 | Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх. | - | -Хяналт-шинжилгээ үнэлгээний цахим системд байршуулсан 2023 оны гэрээний тоо<br>-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тоо | Хагас бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байна | -20 сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Аймгийн Засаг даргатай сумдын Засаг даргын байгуулсан 2022 оны гэрээний хэрэгжилтийг 2023 оны 01 дүгээр сард дүгнэж, сумдын Засаг даргын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд оруулж, аймгийн Засаг даргын захирамжаар дүнг баталгаажуулсан. Сумын Засаг дарга бүрт зөвлөмжийг бичиж хүргүүлсэн.<br>Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээнд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Гэрээний дундаж хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 90.98 хувьтай байна. | 100% |
| 19.4 | Аймгийн Засаг дарга Орон нутгийн өмчийн байгууллагын дарга нарын хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | - | Гэрээний үүргийн хэрэгжилтийг үнэлсэн байх | 2022 оны эхний хагас жилийн | --7 орон нутгийн өмчийн байгууллага, 3 босоо | Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит 10 байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг дарга баталгаажуулж, 2023 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэсэн. | удирдлагатай төсөвт байгууллагын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн дундаж үнэлгээ 84.76 хувьтай байна. | |
| 19.5 | Ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах ажлыг зохион байгуулах. | - | -Цахим тайланд үнэлгээ хийх<br>-Нэгдсэн тайланг Засгийн газарт тайлагнасан байх | Хагас , бүтэн, жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байна. | цахим системээр тайлагнадаг 53 байгууллагын цахим тайланд үнэлгээ хийнэ. | Аймгийн Засаг даргын Тамгын газрын ил тод байдлын тайланд үнэлгээ хийж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Байгууллагын ил тод байдлын шалгуурыг 2022 оны жилийн эцсийн байдлаар тайлагнасан 47 байгууллага, 2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнасан 41 байгууллага, нийт 88 байгууллагын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн.<br>2023 оны жилийн эцсийн тайланг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний bayankhongor.igovernment.mn цахим системээр хүлээн авч эхэлсэн. | 100% |
| 19.6 | Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга | - | -Бодит хэрэгжилтийн үр дүнг тооцсон байх<br>-Засгийн газарт тайлагнасан байх | Өмнө үнэлж байгаагүй | -20 сум, 34 байгууллагын | Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг аймгийн Засаг даргын 2023 оны А/78 дугаар | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх | | | | Тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээнд хяналт шинжилгээ хийх, зөвлөмж өгөх | захирамжаар байгуулагдсан мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг үнэлж дүгнэлээ. Тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2022 онд 211.0 мянга гаруй мод тарьж, ургалтын хувийг 70 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд 522,808 ширхэг мод, бут, сөөгийг тарьж ургалтын хувь 70,6 хувьд хүрсэн байна.<br>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийг хэлэлцэн баталсан. Тус хөтөлбөр нь 4 бүлэг 26 зорилтоос бүрдэх бөгөөд хөтөлбөрийн 70,64 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.<br>Баянхонгор аймаг цахим засаглал, цахим шилжилтэд төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан “ДИЖИТАЛ БАЯНХОНГОР” болох томоохон зорилтыг дэвшүүлэн ажилласан ба хэрэгжилтийг 90 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.<br>Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн. Нэгдсэн тайлан, илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлж ажилласан. | |
| 19.7 | Агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | - | -Шалгуур үзүүлэлтийг үнэлж, зөвлөмж өгсөн байх | 2022 оны эхний хагас жилийн | -34 байгууллагын Тэргүүлэх ач холбогдолтой | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлаг, 10 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой 127 шалгуурын 142 үзүүлэлтээс үзүүлэлтээс 22 байгууллага 122 шалгуурыг 137 үзүүлэлтэд үнэлгээ хийхэд дундаж гүйцэтгэл 2022 оны жилийн эцсийн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байдлаар үнэлсэн | төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээнд хяналт шинжилгээ хийх, зөвлөмж өгөх | байдлаар 85,3 хувьтай байсан. Хангалтгүй үзүүлэлттэй байсан байгууллагуудад холбогдох зөвлөмжийг нэгдсэн зөвлөмжид тусгаж хүргүүлсэн. | |
| 19.8 | Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих | - | 20 сумыг бүрэн хамруулсан байх | Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системд 2022 оны эхний хагас жилийн | Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төлөвлөлтөд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт | Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн системийн ашиглалтад 2024 оны төлөвлөлтийг багийн ИНХ-аар хугацаанд нь хэлэлцэж баталсан эсэх, Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх иргэдийн саналыг эрэмбэлэх ажлын хэсэг байгуулагдсан эсэх, Төсвийг хуулийн хугацаанд, маягтын дагуу баталсан эсэх, ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүнг сумын албан ёсны цахим хуудсаар мэдээлсэн эсэх, 2022 оны хөрөнгийг өмчид бүртгэсэн эсэх үзүүлэлтээр хийж, дүн, зөвлөмжийг сумдын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланд нэгтгэн хүргүүлсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байдлаар үнэлгээ хийгдсэн | зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг хангуулсан байна | | |
| 19.9 | Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | - | -Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг гаргах,<br>-Засгийн газарт тайлагнасан байх | Жил бүр эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг гаргадаг. | Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг гаргаж, заасан хугацаанд Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байх | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн 2022 оны жилийн эцсийн үнэлгээ 82 хувьтай гарсан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт журамд заасан хугацаанд хүргүүлсэн. 2023 оны үнэлгээ 2024 оны 01 дүгээр улиралд гарна. | 100% |
| 19.10<br>. | Хяналт шинжилгээ, үнэлгээний 2022 оны тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх | - | Журамд заасан хугацаанд ЗГХЭГ-т тайлагнасан байх | Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тайланг хүргүүлсэн. | Эхний хагас жилд: Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн | Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг журамд заасан хугацааны дотор буюу 2023 оны 03 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайланг хүргүүлсэн байх | | |
| **Зорилт-20.Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангах** | | | | | | | |
| 20.1 | Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах | 2.6 сая | Хамрагдсан иргэдийн тоо, хэрэгжилтийн хувь | 95% | 100% | Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 21 жилийн ой, энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан Баянхонгор аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээний дагуу ерөнхий боловсролын сурагчид, иргэд олон нийтэд Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах, цэрэг-эх оронч хүмүүжил олгох, Монгол цэргээрээ бахархах үзлийг төлөвшүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн өв тэгш хүмүүжил олгох зорилгоор Зэвсэгт хүчний 339 дүгээр ангитай хамтран Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг Баян-Овоо болон Эрдэнэцогт сумдад зохион байгуулж явууллаа.<br>Нээлттэй хаалганы өдөрлөгийн хүрээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид урлагийн үзүүлбэр, жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолт, олс таталт, гир өргөх үзүүлэх тоглолт, модон морь дээгүүр харайх, суга савлуурт өнцөг барих 3 цэгийн зогсолт зэрэг цэрэгжилтийн спортын үзүүлэх тоглолт байлдааны зэвсэг, техник, ажил үүргийн онцлогыг тусгасан үзэсгэлэн, мэдээлэл сурталчилгааг тус тус зохион байгууллаа | 100% |
| 20.2 | Зэвсэгт хүчний 102 жилийн ой, чөлөөлөх дайны 78 жилийн ойн баярын арга хэмжээг зохион байгуулах, сурталчлах | 5.0 сая | Зохион байгуулсан арга хэмжээний тоо,<br>-Хандалтын хувь | -9.6 сая<br>-11<br>-240 | -10.0 сая<br>-14<br>-300 | Зэвсэгт хүчний 102 жилийн ой “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/126 дугаар захирамжаар батлагдсан | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөрийн дагуу Цэргийн штабаас “Модон морин дээгүүр харайх” тэмцээн, Цагдаагийн газар Сагсан бөмбөгийн тэмцээн, Онцгой байдлын газар Волейболын холимог тэмцээн, Зэвсэгт хүчний 339 дүгээр анги Олс таталтын тэмцээн, Шүүхийн шинжилгээний алба “Биллиард”-ны тэмцээн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар “Хүчит бөхийн барилдаан”, Тагнуулын хэлтсийн үндэсний “Шагай харваа”-ны тэмцээн зэрэг спортын уралдаан тэмцээнүүд болон аймгийн Засаг даргын нэрэмжит “Марш тактикийн аварга тасаг” шалгаруулах тэмцээнийг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн сургалтын хээрийн байрлалд амжилттай зохион байгуулж явууллаа.<br>Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 01/558 тоот албан даалгаврын дагуу Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийг ойг угтсан Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчнийг сурталчилсан контентыг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангитай хамтран хийж орон нутгийн телевиз, мэдээллийн сайтуудаар иргэд, олон нийтэд түгээсэн. | |
| 20.3 | Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд Цэрэг спортын “Дөл-2023” цогцолбор тэмцээнийг зохион байгуулах | 8.0 сая | Тэмцээнд оролцох багийн тоо | 8 | 12 | Багууд удирдамжийн дагуу бэлтгэсэн мэндчилгээг дэвшүүлж, тасгийн захирагчийн тэмцээн, мэдлэг сорих асуулт зэрэг даалгавруудыг биелүүлж, жагсаалын үзүүлэх тоглолтыг чөлөөт сэтгэлгээгээр хөгжмийн аянд болон бөмбөрийн үргэлжилсэн цохилтон доор хийж гүйцэтгэлээ. Гарааны өмнөх дасгалуудыг хийж гүйцэтгэснээр тасгууд бэлтгэсэн маршрутын дагуу гараанаас гарч цэг-1 /модон морин дээгүүр харайх/, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэг-2 /дугуйн саад/, цэг-3 /эмнэлэг/ зэрэг цэгүүдийн туулан 3 километр замыг туулан барианд орлоо. Нэгдсэн дүнгээр ахлах ангийн насны ангилалд тэргүүн байранд Баянцагаан сумын "Сүлд" тасаг, дэд байранд Эрдэнэмандал ахлах сургуулийн "Буянт-Богд" тасаг, гутгаар байранд Жаргалант сумын "Тэмүүлэл" тасаг, дунд насны ангилалд тэргүүн байранд Жаргалант сумын "Өсөх Ирээдүй" тасаг, дэд байранд Бууцагаан сумын "Буянт" тасаг, гутгаар байранд Бөмбөгөр сумын "Гэрэлт Цох" тасгийн хамт олон тус тус шалгарч алт, мөнгө, хүрэл медалийн эзэд болж мөнгөн шагналаар шагнагдав. | |
| 20.4 | Ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгуулах | 3.8 сая /Байгууллагын төсөв/ | Хяналтын тоо биелүүлсэн хувь | 100% | 100% | Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын "Цэрэг халах, татах ажлыг зохион байгуулах тухай" 2023 оны н/60, мн/190 дүгээр тушаалын дагуу Баянхонгор аймгийн I ээлжийн цэрэг татлагыг 04 дүгээр сарын 19-27, II ээлжийн цэрэг татлагыг 09 дүгээр сарын 29-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийг дуустал тус тус зохион байгуулсан.<br>Ээлжит цэрэг татлагын нэгдсэн сургалтыг аймаг, сумын Засаг даргын захирамжаар томилогдсон цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнтэй цахим болон танхимын хэлбэрээр явуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Хугацаат цэргийн албаны татлагын ажлыг Өлзийт, Бууцагаан, Хүрээмарал, Гурванбулаг, Жаргалант, Галуут Баян-Овоо, Эрдэнэцогт, Баянговь, Заг, Баянхонгор сумдын товчооны бүрэлдэхүүн сайн зохион байгуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20.5 | Цэргийн албаны тухай хууль Цэргийн бүртгэлийг хөтлөх, зохион байгуулах | 1.2 сая /Байгууллагын төсөв/ | --Цэргийн бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн хувь | -100% -90% | -100% -95% | Аймгийн Засаг даргын "Цэргийн бүртгэл"-ийг явуулах тухай А/738 дугаар захирамжаар Цэргийн бүртгэлийн ажлыг цахим болон цаасан хэлбэрээр хослуулан 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 13-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгууллаа. Тус оны Цэргийн бүртгэлд Жинст, Богд, Баянговь, Баянлиг, Баацагаан, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Жаргалант, Эрдэнэцогт, Баян-Овоо, Өлзийт сумдууд 90%-100%, Баянхонгор, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Бөмбөгөр, Галуут, Гурванбулаг, Заг сумдын иргэд 80%-90% тус тус хамрагдаж, аймгийн хэмжээнд бүртгэл 90.3 хувьтай явагдлаа.<br>Е-Монгол цахим бүртгэлийн талаарх бичлэгийг сум бүрийн зарын нэгдсэн групп болон цэргийн бүртгэл явуулах зааланд нь байнгын ажиллуулах заавар чиглэл өгсөн нь бодит үр дүнд хүрч, өмнөх оноос 5.45 хувиар илүү хүн цахимаар бүртгүүллээ. | 100% |
| 20.6 | Зэвсэгт хүчний анги, салбаруудтай дайчилгааны хамтарсан тодотгол явуулах | - | Дайчилгааны тодотгол хийсэн тоо | 0 | 6 | "Аймаг, сумдын байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлж, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө"-ний эдийн засгийн үзүүлэлтийн дайчилгааны төсөвт, бэлтгэл үүрэгтэн, техникийн чанар байдлуудад тус бүр тодотгол хийн өгүүлбэр акт үйлдэн хавсаргасан. Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын Б, Ө, О, Бү зэрэгт тогтоосон хугацаанд шилжүүлэх үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг дараах хүрээнд тодотгосон.<br>• Зарлан мэдээлэл, аюулгүй байдал | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Цэргийн бэлтгэл сургуулалт, сурган дадлагажуулах<br>• Батлан хамгаалах газрыг дэлгэн ажиллуулах<br>• Орон нутгийн цэргийн отряд, суманг байгуулах<br>• Кибер халдлага, довтолгооноос урьдчилан сэргийлэх<br>Дайчилгааны даалгавартай анги салбаруудтай тогтоосон хугацаанд тодотголыг хийж байна | |
| **Зорилт-21. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж шат шатны түвшинд нөөцийг бүрдүүлэх, сургалт дадлагыг зохион байгуулан удирдлага зохион байгуулалтаар хангах** | | | | | | | |
| 21.1 | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу Баянговь, Бууцагаан сумын томилгоот нэгжүүдтэй үзүүлэх сургалт зохион байгуулах | 20.0 сая | -Хамрагдсан иргэдийн тоо | -11<br>-тийм<br>-0<br>-0 | -11<br>-тийм<br>-2<br>-80 | Баянхонгор сумын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн Хамгаалалтын суман, Дэг журам сахиулахад дэмжлэг үзүүлэх суман, Цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх суман, Гамшиг, хөнөөх хэрэгслийн хөнөөлтэй тэмцэх суман, Эмнэлгийн суман зэрэг сумангуудтай сургалтыг шинэ суурьшлын бүсэд цугларалтаар зохион байгуулан явууллаа. Тус сургалтад орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн 178 бэлтгэл үүрэгтэн, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 46 алба хаагч, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 27 алба хаагч, тусгай зориулалтын 9 нэгж техник, хүн тээврийн 5 нэгж техник хамрагдлаа. | 100% |
| \\<br>21.2 | Сумын Засаг даргын Тамгын дарга, Багийн Засаг дарга нартай Цэргийн бэлтгэл сургалт явуулах | 5.8 сая | -Сургалт, хамрагдсан алба хаагчдын тоо | -2<br>-108 | -2<br>-125 | Сумдын багийн Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг зохион байгуулан явууллаа. Сургалтад нийт 20 сумдын 105 багийн Засаг дарга нар оролцохоос 97 багийн Засаг дарга оролцож нийт 92,3%-ийн ирцтэйгээр явагдлаа. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сумдын багийн Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтаар “Монгол Улсын Батлан хамгаалах багц хуулиудыг орон нутагт хэрэгжүүлэх”, “Шат шатны сургалтыг зохион байгуулж явуулахад багийн Засаг дарга нарын үүрэг оролцоо”, “Цэргийн бүртгэл, цэрэг татлага явуулахад багийн Засаг даргын үүрэг, цэргийн дүйцүүлэх алба, мөнгөн төлбөр, гэрээт цэрэг элсүүлэх журам”, “Орон нутгийн хамгаалалтын тухай”, “Дайчилгааны тухай хууль” болон дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтад багийн Засаг дарга нарын үүрэг, оролцоо” зэрэг сэдвүүдийн хүрээнд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явууллаа. | |
| 21.3 | Аймгийн цугларах, шилжүүлэх байрны томилгоот бүрэлдэхүүнтэй сургалт, дадлагыг зохион байгуулах | - | -дадлага, сургалтад хамрагдсан бүрэлдэхүүний тоо | -2<br>-47 | -2<br>-47 | Монгол Улсын Дайчилгааны тухай хууль, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 600/01, 600/02 дугаар стратегийн удирдамжууд, мн/283, мн/288, мн/420 дугаар дайчилгааны даалгавруудын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб тус аймаг дахь Зэвсэгт хүчний 339 дүгээр анги, Баянлиг сумын Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 103 дугаар тусгай салбар, Баянговь сумын Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн 143 дугаар тусгай рот салбар, /команд/-уудыг нөхөн хангахаар оногдуулан бүртгэгдсэн бэлтгэл офицер, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн, автотехникүүдэд тус тус тодотгол хийсэн. | 100% |
| **Зорилт-22. Байгууллагын өдөр тутмын алба үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулахад бэлэн байдал, удирдлага зохион байгуулалтаар хангаж, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх** | | | | | | | |
| 22.1 | Байгууллагын алба үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын байр, тавилга, эд хогшил, машин, тоног | Байгууллагын төсөв | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Автомашинуудыг албаны болон томилгоот бусад ажилд бэлэн байлгаж, 25.283.700 төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч, засвар, үйлчилгээ хийн, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах | | | | | нийт 163735 км зам туулж 89,500,000 төгрөгийн бензин шатахуун, шатах тослох материал зарцуулсан байна.<br>-Жолооч Б.Батзориг 67900 км, зам хоног 84, Б.Баатарбилэг 40000 км, зам хоног 76, Ш.Энэбиш 30450 км, зам хоног 101, А.Цэрэнбямба 25385 км , 65 зам хоног тус тус үүрэг гүйцэтгэж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, ажилласан байна. | |
| 22.2 | Нийтийн эзэмшлийн цэвэрлэгээ үйлчилгээ, урсгал засварыг тогтмол хийх | Байгуулл агын төсөв | -Үнэлгээний хувь,<br>-Урсгал засварын тоо | 100%<br>4 | 100%<br>6 | -Засаг даргын Тамгын газар, аймгийн Хөгжимт драмын театр, Тэмүүжин театр, Спортын ордон, Мазаалай зочид буудал, Шинэ суурьшлын бүс, Номгон сургуульд зохион байгуулагдсан 135 удаагийн хуралдаан, уулзалт, сургалт, 18 удаагийн шагнал гардуулах үйл ажиллагаа, нийт 153 удаагийн арга хэмжээний үеийн хурлын заал, бусад танхимуудыг бэлтгэсэн.<br>-Сар бүрийн эхэнд үйлчлэгч нарыг цэвэрлэгээ, үйлчилгээний материалаар хангаж, жилийн хугацаанд 9.489.060 төгрөгийн цэвэрлэгээний материалаар 801600 м2 талбайг үйлчилгээний стандартын дагуу цэвэрлэсэн.<br>-Ажлын бус цагаар болон цаг үеийн томилгоот ажилд үйлчлэгч нарыг 21 удаа, бусад ажилтнуудыг 19 удаа, нийт 40 удаа нэгдсэн журмаар ажиллуулсан.<br>-Гадна орчны цэвэрлэгээ, зэрлэг зулгаах, цас цэвэрлэх ажлыг 30 удаа албаны бүрэлдэхүүний хүчээр зохион байгуулж, 7 хоног бүр хог ачуулсан. | 100% |
| 22.3 | Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, гэрэлтүүлэг, цахилгааны материал, автомашин, сэлбэг, хурлын | Байгуулл агын төсөв | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Аймгийн ЗДТГ-ын алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, алба хаагчдад аюулгүй ажиллагааны заавარчлагаа өгч, жолооч нарыг албан ажлаар явах бүрд баталгаа авч | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | танхимын техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах | | | | | ажилласан ба энэ хугацаанд ямар нэгэн осол, зөрчилгүй ажилласан. -Өрөө, тасалгааны цахилгааны болон сүлжээний утаснуудын аюулгүй байдлыг хангаж, далдалсан; -Тамгын Газрын байрны гадна хэсэгт туузан гэрэл, камерууд суурилуулж, орчны гэрэлтүүлэг, үзэмжийг сайжруулан, цахилгааны монтаж, дотно, гадна гэрэлтүүлэг, цахилгааны шитэд мэргэжлийн байгууллагатай хамтран үзлэг шалгалт хийж, 1,5 сая төгрөгийн кабель утас, 3,8 сая төгрөгийн гэрэлтүүлгийн хэрэгсэл нийт 5,8 сая төгрөгийн материал хэрэгсэл худалдан авч засварлан аюулгүй байдлыг хангасан; -Тамгын газрын аваарын нөөц хаалга, гарцны хаалган дээр фосфортой “Exit” гэрэлтэгч тэмдэглэгээ хийж, байрлуулсан; -Тамгын газрын өрөө, тасалгаа танхимуудад галын аюулгүй байдлын 300 ш санамж байрлуулсан; -Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор Тамгын газрын өрөөнүүдийн цахилгааны байдалд 2 удаа үзлэг шалгалт хийж, дутагдлыг засуулсан; -Баяр наадмын арга хэмжээний үйлчилгээнд явах авто машин, бензин, шатахууны тооцоо, судалгаа гаргаж, авто машинуудад үзлэг хийж, жолооч нарт аюулгүй ажиллагааны зааварчлагаа өгч, баталгаа авч ажилласан; -ЗДТГ, Төрийн архивын байранд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал халдваргүйжүүлэлт 8 удаа, хортон шавьж, мэрэгч устгах ажлыг 2 удаа, өрөө, танхимуудад мөөгөнцөрийн шинжилгээ 1 удаа холбогдох | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагуудтай хамтран хийсэн;<br>-Үйлчилгээний алба хаагчдад нэг загварын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, малгай, бээлийгээр хангасан. | |
| 22.4 | Ариун цэврийн өрөөнүүдэд засвар үйлчилгээ хийх | 10.0 сая Байгууллагын төсөв | Эрүүл ахуйн шаардлага хангасан орчин бүрдсэн байх | | 100% | Ариун цэврийн өрөөнүүдэд үзлэг шалгалт хийж, 6 ш суултуур, ариун цэврийн өрөөний 6 ш хаалга шинээр солж, ОО-ын кабиныг өргөн болгож засварласан. | 100% |
| 22.5 | Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, гүйлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэх | Байгууллагын төсөв | Хуулийн хэрэгжилтийн хувь | 100% | 100% | НББОУС-тад нийцсэн санхүүгийн ACOLOUS, ТАЦНС, ХНУНС, шилэн данс программууд шинэ технологоор мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна.<br>Санхүүгийн программын үйл ажиллагаа НББ-ийн бодлогын баримт бичигийн заалттай нийцэж байгаа.<br>Санхүүгийн тайлан нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад үндэслэсэн бөгөөд аккурэл суурийг хэрэглэсэн.<br>Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу батлагдсан төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.<br>"Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа мөрдөн нийцүүлэн ажилласан.<br>Төсөвт байгууллагад төлбөр тооцооны гүйлгээ хийх журам АЗДТГ-ын 2021 оны 11 сарын 04-ны А/683 захирамжаар батлагдсан.<br>Байгууллагын төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрхийн актуудыг хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэл, мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлж гаргах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, бусад тайлан мэдээ, хуульд нийцүүлэн гаргасан эрхийн актуудыг хэрэгжүүлж санхүү төрийн сангийн мэргэжилтнээр хянуулан шалгуулж мөрдлөг болгон ажиллаа. | |
| 22.6 | Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт хамгаалалтыг сайжруулах | Байгууллагын төсөв | Өмч хөрөнгийн тооллогыг 2 удаа зохион байгуулах | 100% | 100% | ЗДТГ-ын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс Тамгын газрын 2023 онд хагас бүтэн жилээр үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд 2 удаа тооллого хийж, ололт, дутагдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа ЗДТГ-ын даргад танилцуулж ажилласан. | 100% |
| 22.7 | Дотоод журам, хамтын гэрээний хэрэгжилтийг хангах | Байгууллагын төсөв | Журамд заасан албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, тусламж, дэмжлэгт хамруулсан албан хаагчдын тоо, хэрэгжилтийн хувь | 50% | 100% | Байгууллагын хамтын гэрээнд заасны дагуу 2023 онд давхардсан тоогоор 44 албан хаагчид 9.700.000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн тусламж, 34 албан хаагчид түлшний хөнгөлөлтөд 5.100.000 төгрөг нийт 14.800.000 төгрөгийн тэтгэмж, дэмжлэг олгосон. | 100% |
| 22.8 | ISIO-чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Байгууллагын төсөв | Стандартын хэрэгжилтийн хувь | 40% | 60% | Олон улсын стандарт ISO 9001 чанарын менежментийн тогтолцоог байгууллагад дахин нэвтрүүлэхтэй холбоотойгоор сургагч багш бэлтгэх сургалтад 10 албан хаагч, тус стандартын сургалтын байгууллагын зөвлөх, ахлах аудиторыг орон нутагт урьж, байгууллагын нийт албан хаагчдыг 2 өдрийн танхимын сургалтад тус тус хамруулсан. Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор хэрэгжүүлэгч багт байгууллагын албан хаагчдыг байгууллагын даргын 2023 оны 1а/63 дугаар тушаалаар томилж, стандартыг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хханган ажиллаж байна. | 50% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22.9 | Төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах | Байгууллагын төсөв | шилэн дансанд байршуулсан мэдээллийн тоо, тайлагналтыг хувь | 50% | 100% | Байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэн байгууллагын тухайн жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.shilendans.gov.mn/ цахим хуудсаар олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй харах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.<br>Санхүүгийн ил тод байдлыг иргэдэд нээлттэй байлгахын тулд самбар гарган төсвийн орлого зарлагын мэдээ, сарын хүсэлт баталгааг сар бүр гарган мэдээлж байна. "Шилэн данс"-ны хуулийн хүрээнд байгууллагын орлого, зарлагуудыг сар бүр байгууллагын самбарт болон цахим хуудсанд байрлуулж байна. Байгууллагын санхүүгийн тайлан мэдээллийг шилэн данс, Bayankhongor.gov.mn сайт, байгууллагын мэдээллийн ил тод самбарт тогтмол байршуулж ажиллаж ирсэн. | 100% |

ХЯНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА /Д.МӨНХСАЙХАН/
2024 оны ..... сарын .....

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА /Д.ЭНХЖАРГАЛ/
2024 оны 01 сарын 11.

0320110002
9007342 ГСТ7121